



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/78

Арвайхээр

“Эрх зүйн сургалт, сурталчилгааны талаар  
авах арга хэмжээний тухай”


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, Засгийн газрын 1993 оны “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай” 57 дугаар тогтоолын 3 дахь заалт, 1996 оны “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай” 66 дугаар тогтоолын 4 дэх хэсгийн “г” заалтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн эрх зүйн боловсрол олгох, хууль тогтоомжийг олон нийтэд нэг мөр ойлгуулах, эрх зүйн мэдээллийг бэлтгэн түгээх орон тооны бус аймгийн “Эрх зүйн сургалт, сурталчилгааны баг”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сумдын “Эрх зүйн сургалт, сурталчилгааны баг”-ийн бүрэлдэхүүний үлгэрчилсэн загварыг хоёрдугаар, аймгийн 2018 оны Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх, нийтэд сурталчлахтай холбогдсон үүргийг төрийн албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тодорхой тусган биелэлтийг дүгнэж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдлагууд, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөнд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгуулан ажиллахыг Хууль зүйн салбар хариуцсан аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хэрэгжилтэд хяналт тавин, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (А.Отгонцэцэг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100173

Аймгийн Засаг даргын 2018 оны 02  
дүгээр сарын 09-ны өдрийн 1177 дүгээр  
захирамжийн нэгдүгээр хавсралт

## НЭГ.АЙМГИЙН “ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч: аймгийн Засаг даргын орлогч (Хууль зүйн салбар хариуцсан)  
Нарийн бичгийн дарга: аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн  
хэлтсийн Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны асуудал  
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

### 1. Хууль, хяналтын салбар:

- Аймгийн Шүүхийн Мэдээлэл, лавлагааны ажилтан (зөвшилцснөөр)
- Аймгийн Прокурорын газрын Сургалт, мэдээлэл хариуцсан ажилтан  
(зөвшилцснөөр)
- Аймгийн Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах  
мэргэжилтэн
- Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Сургалт, мэдээлэл хариуцсан ажилтан
- Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны Кримналастикийн шинжээч
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Харилцаа холбоо, хэмжил зүйн хяналтын  
улсын байцаагч
- Аймгийн Онцгой байдлын газрын Сургалт, сурталчилгаа урьдчилан сэргийлэх  
асуудал хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Эзлэхүүн зарцуулалтын хэмжүүрийн  
улсын шалгагч

### 2. Нийгмийн салбар:

- Аймгийн Эрүүл мэндийн газрын Хууль, эрх зүйн мэргэжилтэн
- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хүний нөөц, дотоод ажил  
хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын Сургалт, судалгаа, арга зүйн хэлтсийн  
дарга
- Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Сургалт, сурталчилгааны  
асуудал хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Биеийн тамир, спортын газрын Биеийн тамирын спортын албаны дарга
- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгийн дарга
- Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Сургалт, сурталчилгаа, мэдээллийн  
технологи хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Эрүүл мэндийн даатгалын тасгийн зардал хариуцсан байцаагч
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Насан туршийн боловсролын төвийн ахлах  
мэргэжилтэн

### 3. Эдийн засаг, хөдөө аж ахуйн салбар:

- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Татварын хэлтсийн улсын ахлах байцаагч
- Аймгийн Стастикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны улсын ахлах байцаагч
- Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүний нөөц, дотоод ажил хариуцсан  
мэргэжилтэн
- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Бодлогын хэрэгжилт, хүний  
нөөц хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Хүний нөөц, дотоод  
ажил хариуцсан ажилтан
- Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны Хүний нөөц, бичиг хэргийн  
ажилтан

Аймгийн Засаг даргын 2018 оны 02  
дугаар сарын 09-ны өдрийн 177 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

**ХОЁР.СУМЫН “ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ БАГ”-ИЙН  
БҮРЭЛДЭХҮҮНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

Багийн ахлагч: Сумын Засаг даргын Тамгын газрын дарга  
Нарийн бичгийн дарга: Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны түшмэл

- Гишүүд: -Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан
- Сум хариуцсан хөдөлмөр, халамжийн ажилтан
  - Цагдаагийн албан хаагчийн төлөөлөл
  - Хүүхэд, гэр бүл, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн
  - Улсын бүртгэгч
  - Газрын даамал
  - Байгаль орчны хяналтын улсын байцаагч
  - Татварын улсын байцаагч
  - Нийгмийн даатгалын байцаагч
  - Мал эмнэлэг үржлийн тасгийн улсын байцаагч зэрэг холбогдох албан хаагчид

-oOo-

Аймгийн Засаг даргын 2018 оны 23 дугаар сарын 23-ны өдрийн 177 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



**АЙМГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ  
АЖЛЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго: Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр ойлгуулах, хууль, эрх зүйн сургалт, мэдээллийг тогтмол, хүртээмжтэй сурталчилахад чиглэгдэнэ.

д/д	Агуулга, сэдэв	Хугацаа /улирал, сар/	Хамрах хүрээ /зорилтод бүлэг/	Хүрэх үр дүн	Зохион байгуулах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
<b>Нэг. Төрийн байгууллага, албан хаагчдад чиглэсэн сургалт</b>						
1.	Төрийн албаны тухай хуулийн сургалт /шинэчилсэн найруулга/	3-4 улиралд	Төрийн албан хаагчид	Хуулийн шинэлэг зохицуулалтын талаарх мэдээллийг олгосон байна.	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ
2.	Зөрчлийн тухай хуулийн сургалт	Жилдээ	Төрийн албан хаагчид	Хууль, эрх зүйн мэдлэг дээшилж хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл нэмэгдэнэ.	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, Сумдын ЗДТГ	Аймгийн Прокурорын газар
3.	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудлын талаарх арга зүйн сургалт	Жилдээ	Эрх бүхий албан тушаалтнууд /улсын байцаагчид/	Хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл нэмэгдэнэ.	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ	Аймгийн Прокурорын газар
4.	БОХУБайцаагч, байгаль хамгаалагчдыг чадавхижуулах эрх зүйн сургалт	4 дүгээр улиралд	БОХУБайцаагч, байгаль хамгаалагч	Албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг дээшилнэ.	Аймгийн БОАЖГ	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, аймгийн МХГ
5.	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн сургалт	2-3 дугаар улиралд	Сумын мал эмнэлэг, үржлийн тасаг, хувийн мал эмнэлэг, үржлийн нэгж, малчид	Зорилтод бүлгийн иргэдэд мэдээллийг олгосон байна.	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ	Аймгийн ХХААГ Сумдын ЗДТГ

6.	Малын генетик нөөцийн тухай хуулийн сургалт	2-3 дугаар улиралд	Сумын мал эмнэлэг, үржлийн тасаг	Зорилтод бүлэгт мэдээллийг өгсөн байна.	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ	Сумдын ЗДТГ
7.	Нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлэх чиглэлээрх сургалт	Жилдээ	Төрийн албан хаагчид	Иргэдэд нэгдсэн мэдээллийг олгосон байна.	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс	Сумдын ЗДТГ
9.	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн талаарх арга зүйн сургалт	2-4 дүгээр улиралд	ЕБС-ийн багш нар	Холбогдох хууль, тогтоомжийн талаарх мэдээллийг 500-аас доошгүй багш нарт хүргэсэн байна.	Аймгийн БСУГ	ГБХЗХГ
10.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, шилэн дансан дахь мэдээллийг хэрэглэх тухай сургалт	Жилдээ	Шалгагдаж буй байгууллагын тоогоор	Хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэнэ.	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба	Шалгагдсан байгууллагууд
11.	Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага сэдэвт сургалт	Жилдээ	Төрийн албан хаагчид	Төрийн албан хаагчийн ёс зүй дээшилнэ.	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ	Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ
12.	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах тухай хуулийн сургалт	2 дугаар улиралд	Төрийн албан хаагчид	Хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэнэ.	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ	Сумдын ЗДТГ
13.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн сургалт	Жилдээ	Худалдан АЗ сертификаттай төрийн албан хаагч, иргэдэд	Худалдан авах ажиллагаантай холбоотой гомдол мэдээлэл гараагүй байна.	Аймгийн Орон нутгийн газар өмчийн	Холбогдох төрийн байгууллагууд
14.	Байгууллагуудын сургалт, мэдээлэл хариуцсан албан хаагчид болон сумдын Хууль, эрх зүйн сургалт, мэдээлэл хариуцсан албан хаагчдыг чадавхижуулах эрх зүйн сургалт	2 дугаар улиралд	Холбогдох албан хаагчид	Аймгийн Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын зохион байгуулалт сайжирна.	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ	Аймгийн ГХУСАЗЗ Сумдын ЗДТГ
15.	Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд анхаарах асуудал сэдэвт арга зүйн сургалт	3-4 дүгээр улиралд	Төрийн албан хаагчид	Төрийн үйлчилгээ сайжирна.	Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ	Удирдлагын акедеми

**Хоёр. Иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн сургалт**

16.	Захиргааны ерөнхий хуулийн сургалт	Жилдээ	Иргэд	Төрийн байгууллагуудын шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн хяналт, оролцоо нэмэгдэнэ.	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ	Сумдын ЗДТГ
17.	Зөрчлийн тухай хуулийн сургалт	Жилдээ	Иргэд	Эрх зүйн мэдлэг нэмэгдэнэ.	Аймгийн Прокурорын газар, Аймгийн Цагдаагийн газар	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, Сумдын ЗДТГ
18.	Хоршоо хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр сурталчлах мэдээлэл, сургалт	2-3 дугаар улиралд	Иргэн, аж ахуйн нэгж, тариаланчид	Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана.	Аймгийн ХХААГ	Сумдын ЗДТГ
19.	Гамшгаас хамгаалах тухай тухай хуулийн сургалт	Жилдээ	Аж ахуйн нэгж, байгууллага	Гамшгаас өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах мэдлэг чавдартай болно.	Аймгийн Онцгой байдлын газар	Сумдын ЗДТГ
20.	Галын аюулгүй байдлын тухай хуулийн сургалт	Жилдээ	Аж ахуйн нэгж, байгууллага	Гамшгаас өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах мэдлэг чавдартай болно.	Аймгийн Онцгой байдлын газар	Сумдын ЗДТГ
21.	Малчны тэтгэврийн тухай хууль, тэтгэврийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх сургалт, мэдээлэл	1-2 дугаар улиралд	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид	Зорилтод бүлэг бодитой мэдлэг мэдээлэлтэй болно.	Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс	Сумдын ЗДТГ
22.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн сургалт, холбогдох эрх зүйн актын талаарх сургалт	Жилдээ	Зорилтод бүлгийн иргэд	Зорилтод бүлэг бодитой мэдлэг мэдээллийг олгосон байна.	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс	Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Сумдын ЗДТГ
23.	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах тухай хуулийн сургалт	Жилдээ	Иргэд	Хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл нэмэгдэнэ.	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс	Сумдын ЗДТГ, АТГ-ын олон нийтийн зөвлөл
24.	Архидалтгүй-Өвөрхангай, Аюулгүй Иргэн-Амар Тайван Өвөрхангай хөтөлбөрийн танилцуулга, сургалт	2 дугаар улиралд	Иргэд	Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэнэ.	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Аймгийн Цагдаагийн газар	Сумдын ЗДТГ
25.	Хөдөлмөрийн харилцаанд			Хөдөлмөрийн	Аймгийн Хөдөлмөр,	Аймгийн МХГазар

	оролцогч талуудын нийтлэг эрх үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээрийн талаарх сургалт	3-5 дугаар сард	Иргэд	харилцаатай холбоотой зөрчил маргаан буурсан байна.	халамжийн үйлчилгээний газар	ӨВ аймаг дахь Хүний эрхийн үндэсний комисс
26.	Боловсролын талаарх хууль, тогтоомж, аймгийн хөтөлбөрүүд, оюутны хөгжлийн зээл болон бусад холбогдох эрх зүйн актын талаарх мэдээлэл, сургалт	2-4 дүгээр улиралд	ЕБС-ийн сурагчдын эцэг, эхчүүдэд	1000-аас доошгүй иргэдэд мэдээлэл хүргэсэн байна.	Аймгийн БСУГ	Сумдын ЕБС-ын захиргаа
27.	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн талаарх сургалт	Жилдээ	ЕБС-ийн сурагчдын эцэг, эхчүүдэд	Хуулийн талаарх нэгдсэн ойлголт мэдээллийг хүргэсэн байна.	Аймгийн БСУГ	Аймгийн ГБХЗХГ, Сумдын ЗДТГ
28.	Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн сургалт	2-3 дугаар улиралд	Байгаль орчин, геологи уул уурхайн чиглэлээр ажиллагаа явуулдаг байгууллагууд	Эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэлтэй болно.	Аймгийн МХГ	Сумдын ЗДТГ
29.	Газрын тухай хууль, газар өмчлөлийн талаарх сургалт	Жилдээ	Иргэдэд	Газрын харилцаатай холбоотой иргэдийн эрх зүйн мэдлэг нэмэгдэнэ	Аймгийн ГХБХБГ	Сумдын ЗДТГ
<b>Гурав. Хүүхэд, залуучуудад чиглэсэн сургалт</b>						
30.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн сургалт	Жилдээ	ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчид	Сурагчдад зөв мэдлэг хандлага төлөвшүүлнэ.	Аймгийн БОАЖГ	Аймгийн БСУГ
31.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн сургалт	Жилдээ	МСҮТөвийн болон ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчид	Хууль, эрх зүйн мэдлэг нэмэгдэнэ.	Аймгийн ГБХЗХГ	Аймгийн Цагдаагийн газар
32.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн сургалт, мэдээлэл	Жилдээ	Залуучууд	Хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэнэ.	Аймгийн ГБХЗХГ	Сумдын ЗДТГ
33.	Нийгмийн даатгалын багц хуулийн мэдлэг олгох сургалт	2-3 дугаар улиралд	МСҮТөвийн болон ЕБС-ийн ахлах ангийн сурагчид	Хууль эрх зүйн мэдлэг нэмэгдэнэ.	Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс	МСҮТөвийн болон ЕБС-ийн захиргаа

34.	2018 оны ЭЕШ-ын журам, их дээд сургуульд оюутан элсүүлэх журмын танилцуулга, мэдээлэл	2-3 дугаар улиралд	ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагчид, ЭЕШ-бүртгүүлэгчид	Журмын талаар нэгдсэн ойлголт мэдээлэлтэй болсон байна.	Аймгийн БСУГ	Сумдын ЗДТГ
35.	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон архи, согтууруулах ундааны хор уршгийн талаарх сургалт	Жилдээ	МСҮТөвийн сурагчдад	Сургалт, мэдээллийг олгосон байна.	Аймгийн Мэргэжлийн баг	Аймгийн МСҮТ
<b>Дөрөв. Лекц, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, өдөрлөг зохион байгуулах</b>						
36.	Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт түүний үр ашиг хэлэлцүүлэг	4 дүгээр улиралд	Холбогдох байгууллагуудын албан хаагчид	Хэлэлцүүлгийн үр дүнг дээд шатны байгууллагад танилцуулж, санал оруулсан байна.	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ
37.	"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд талуудын оролцоог нэмэгдүүлэх нь" Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн	2 дугаар улиралд	Хуулийн байгууллагуудын албан хаагчид	Зөвлөгөөнөөс санамж бичиг гаргаж гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд талуудын оролцоог нэмэгдүүлнэ.	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Аймгийн Цагдаагийн газар	Аймгийн ГХУСАЗЗ, Хуулийн байгууллагууд
38.	Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн зөвлөгөө мэдээлэл өгөх өдөрлөг	1-3 дугаар улиралд	Иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид	Иргэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна.	Аймгийн ХХҮГазар	Сумдын ЗДТГ
39.	Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд "Анги удирдсан багш" нарын зөвлөгөөн	1-2 дугаар улиралд	Анги удирдсан багш нар	Хүүхдийн хөгжил, хамгаалалд анги удирдсан багш нарын үүрэг оролцооны талаар нэгдсэн ойлголттой болсон байна.	Аймгийн БСУГ	ГБХЗХГазар
40.	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон холбогдох журмын талаар хэлэлцүүлэг	1 дүгээр улиралд	Архи, согтууруулах ундааны тусгай тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, иргэд, иргэний зөвлөл	Хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэнэ.	Аймгийн ЦГ, МХГ	Аймгийн ЗДТГазрын Хууль, эрх зүйн хэлтэс
<b>Тав. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах</b>						

41.	Тарвага агнахыг хориглосон шийдвэрийг сурталчлах	Жилдээ	Иргэд	Хууль бусаар тарвага агнахыг бууруулна.	Аймгийн БОАЖГазар	Орон нутгийн Хэвлэл мэдээллийн байгууллага
42.	Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн сурталчилгаа	Сар бүр	Иргэд даатгуулагчид	Иргэдэд мэдээлэл олгосон байна.	Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	Орон нутгийн Хэвлэл мэдээллийн байгууллага
43.	Малчдын тэтгэврийн насыг наашлуулсантай холбоотой болон бусад холбогдох хуулийн эрх зүйн зохицуулалтын талаарх сурталчилгаа	Жилдээ	Иргэд даатгуулагчид	Малчин, даатгуулагчид малчны тэтгэврийн талаар мэдээ, мэдээлэлтэй болсон байна.	Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага
44.	Архидалтгүй –Өвөрхангай хөтөлбөрийн үр дүн, шинэчилсэн хөтөлбөрийн талаарх нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд хүргэх	2-3 дугаар улиралд	Иргэд	Хөтөлбөрийн талаар иргэдэд тодорхой мэдээллийг хүргэсэн байна.	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, БОЭТ, АА бүлэг	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага
45.	Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудлын талаар нэвтрүүлэг	Жилдээ	Иргэд	Хуулийн талаарх мэдлэг нэмэгдэнэ.	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага
46.	Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомжуудыг сурталчлах шторк, теле зохиомж бэлтгэн олон нийтэд хүргэх	2-4 дүгээр улиралд	Иргэд, ажил олгогчид	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн нөхцөлийн талаарх иргэдийн ойлголт нэмэгдэнэ.	Аймгийн ХХҮГ	Ажил олгогч эздийн холбоо, Орон нутгийн телевизүүд
47.	Хүүхдийн эрх, хөгжил хамгааллын талаарх мэдээллийг сурталчлах	Жилдээ	Иргэд, олон нийт	сард 1-ээс доошгүй мэдээ, мэдээлэл бэлтгэн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлсэн байна.	Аймгийн БСУГ, ГБХЗХГ	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага